



## ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

С.Буяннэмэхийн өргөн чөлөө 2-211, Нутгийн удирдлагын ордон, 7-р баг. Сайнцагаан сум, Дундговь аймаг 48090  
Утас/факс: 70592353 Цахим шуудан: info@dundgovi.gov.mn  
Цахим хуудас: www.dundgovi.gov.mn

2023. 11. 29 № 01/1545

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Г УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМАНД

Уул уурхай, хүнд үйлдвэрийн Сайдаас Дундговь аймгийн Засаг даргатай 2023 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний үүргийн жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийсэн тайланг хүргүүлж байна.

Хавсралт/Ц.Мөнхбат хуудастай.

4823141031

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, УУЛ УУРХАЙН, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН  
САЙД, ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ 2023 ОНД  
БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ**

2023 оны 11 дүгээр сарын 29

Мандалговь хот

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Зарцуулсан хөрөнгө	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хэрэгжилт
<b>НЭГ: САЛБАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР /ГЭРЭЭНИЙ ЗААЛТЫН ХҮРЭЭНД/</b>						
1.1	Улсын төсвийн хөрөнгөөр тухайн орон нутагт хэрэгжүүлж байгаа 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн Их хараат уул-50, Үнэгт уул-50, геологийн сэдэвчилсэн судалгааны Мезо-Кайнозой-2021, Гүний хагарал-1, Геологийн орчин-2022, Мета-алт-500, өндөр технологийн түүхий эдийн ӨТТЭ-2-2022 болон 2023 оноос шинээр хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөж байгаа геологийн судалгаа, эрэл-үнэлгээний төслүүдийн гүйцэтгэгч хуулийн этгээдийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу дэмжих;	-	Дэмжиж ажилласан төслийн тоо	2	2	Монгол Улсын нутаг дэвсгэрийн геологийн тогтцыг судлах, ашигт малтмалын хэтийн төлөвийг тодорхойлох зорилгоор улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны “Их хараат уул -50” төслийг тус аймгийн Адаацаг, Эрдэнэдалай сумын нутагт “Их хараат уул” талбайд “Гео-Мин” ХХК, Үнэгт уул -50 төслийг “Үнэгт уул” талбайд “Монгол Алт” ХХК тус бүр зураглалын ажлаа хийж гүйцэтгэсэн. Уг ажлыг гүйцэтгэхэд холбогдох сумас Засаг даргын Тамгын газраас төслийн ажилтай холбоотой мэдээлэл хүргж үйл ажиллагааг саадгүй явуулахад дэмжлэг үзүүлж ажилласан. Бусад төсөл нь Дундговь аймагт хэрэгжээгүй байна. <b>Хэрэгжилт 100 хувь</b>
1.2	Хуулийн дагуу үйл ажиллагаа явуулж буй ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч, газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээт талбай эзэмшигчийн үйл ажиллагааг орон нутгийн зүгээс дэмжих;	-	Орон нутгийн зүгээс дэмжлэг үзүүлсэн эсэх /Тийм-1, үгүй-0	1	1	Сайхан-Овоо сумын нутагт орших Төгрөг хайрхан уулын орчимд бүтээгдэхүүн хуваах гэрээ бүхий Нүүрсний давхаргын метан хийн хайгуулын үйл ажиллагаа явуулсан “Тахь ресурс” ХХК-ны хайгуулын ёрмийн цооногийн нехэн сэргээлтийг хүлээж авах ажлын хэсгийг Засаг даргын 2023 оны 09 сарын 15-ны өдрийн А/525 тоот захирамжаар байгуулан ажлуулж тус газарт нехэн сэргээлт хийсэн талбайг хүлээн авлаа. <b>Хэрэгжилт 100 хувь</b>

1.3	Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоолоор баталсан "Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх гэрээний загвар"-ын дагуу аймгийн нутаг дэвсгэрт олгогдсон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч бүртэй гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавих, хэрэгжилтийг жил бүр дүгнэх	-	Байгуулсан гэрээний тоо	19	15	2023 онд "Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх гэрээний загвар"-ын дагуу аймгийн нутаг дэвсгэрт олгогдсон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч 15 ААН-тэй гэрээ байгуулан гэрээний хэрэгжилтийн явцад хагас бүтэн жилээр хяналт тавин ажилласнаар гэрээний хэрэгжилт 85,7 хувьтай байна. <b>Хэрэгжилт 100 хувь</b>
1.4	Тухайн аймгийн нутаг дэвсгэрт олгогдсон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгж өөрийн хайгуулын талбайд хайгуулын ажил хийхэд дэмжлэг үзүүлж ажиллах;	-	Гэрээний хэрэгжилтийн хувь	-	80	Aймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий 73 талбай хүчин төгөлдөр байгаагаас Адаацаг суманд Эрдэнийн сан майнинг ХХК, Гурван сайхан суманд Билэгт сайхан уул ХХК, Петро ойл минвеско ХХК нар өрөмдлөгийн хайгуул, Баянжаргалан суманд Тайга зоне ХХК, Эрдэнэдалай суманд Окслей гоулд ХХК геофизикийн хайгуулыг тус тус гүйцэтгэнсээр нийт 5 аж ахуй нэгж хайгуулын ажил гүйцэтгэхэд сумдын Засаг дарга наарт уул уурхайн хайгуулын ажлыг саадгүй хийлгэхийг чиглэл болгосон албан тоотыг хүргүүлж ажилласан. <b>Хэрэгжилт 100 хувь</b>
1.5	Орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудын ашигт малтмалын хайгуул, олборлолтын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй компаниудаас хүлээн авсан мөнгөн болон мөнгөн бус хандивыг dundgovi.gov.mn цахим хаяг болон Дундговь аймгийн Засаг даргын тамгын газар фэйсбуук хуудсаар олон нийтэд мэдээллэхээс гадна Ул уурхайн зөвлөгөөн-2023, Хөрөнгө оруулагчдын чуулга уулзалтыг зохион байгуулж хандивын тайланг мэдээллэсэн. <b>Хэрэгжилт 100 хувь</b>	-	Нийтэд мэдээлсэн сувгийн тоо	1	2	Oрон нутгийн төрийн захиргааны байгууллагуудын ашигт малтмалын хайгуул, олборлолтын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй компаниудаас хүлээн авсан мөнгөн болон мөнгөн бус хандивыг dundgovi.gov.mn цахим хаяг болон Дундговь аймгийн Засаг даргын тамгын газар фэйсбуук хуудсаар олон нийтэд мэдээллэхээс гадна Ул уурхайн зөвлөгөөн-2023, Хөрөнгө оруулагчдын чуулга уулзалтыг зохион байгуулж хандивын тайланг мэдээллэсэн. <b>Хэрэгжилт 100 хувь</b>

1.6	Үйлдвэрийн зориулалттай тэсрэх материалын үйлдвэр, тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулахын байнгын байршлыг тогтоон өгч, агуулахын стандарт шаардлагыг хангуулах, зэрэг ажлыг орон нутагт зохион байгуулах, тогтоогдсон аюулгүй бүсэд газар олгохгүй байх;	-	Шинээр бүртгэгдсэн агуулахын тоо	2	3	2023 онд шинээр Голденсанрайз ХХК, Скайтимбер ХХК, Эрдэнэс алт ресурс ХХК-н тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулахын байнгын байршлыг аймгийн Засаг даргын А/631, А/408, А/359 тоот захирамжуудаар тус тус тогтоож, агуулахын стандарт шаардлагыг хангаж ажиллах зөвлөгөөг өгч ажиллалаа. Уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг 9 аж ахуй нэгжүүдэд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил байхгүй. Тэсэлгээний хэрэгслийн агуулахын байршилаа тогтоолгосон аж ахуйн нэгжүүдэд тогтоогдсон аюулгүйн бүсэд газар олгохгүй байх талаар холбогдох байгууллага, албан тушаалтнуудад үүрэг чиглэл өгч ажилласнаар тэсэлгээний агуулахын тогтоогдсон аюулгүйн бүсэд газар олгогдоогүй. <b>Хэрэгжилт 100 хувь</b>
1.7	Яамны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах бусад асуудлаар орон нутгийн зүгээс дэмжлэг үзүүлж ажиллах;	-	Дэмжлэг үзүүлсэн ААН-н тоо	17	37	Ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 21 аж ахуйн нэгж байгууллагад хайгуулын өрөмдлөг, зам талбайн тоосжилт дарах, унд ахуйн зориулалтаар ус ашиглуулах дүгнэлт гаргаж холбогдох сумд ус ашиглах гэрээ байгуулан ажилласан байна. Ашиглалт, олборлолтын үйл ажиллагаа явуулдаг 2 аж ахуйн нэгжид уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэх маршрутыг баталсан. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн 21 өргөдлийг хүлээн авч АМГТГ-н кадастрын системд бүртгэж, 1 аж ахуйн нэгжид түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр олгож, 11 аж ахуйн нэгжийн түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий талбайд 2 жилээр сунгалт хийж, 1 талбайг цуцлах шийдвэр гарган нийт 37 ААН-н үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажилласан байна. <b>Хэрэгжилт 100 хувь</b>

ХОЁР. САЛБАРТ МӨРДӨГДӨЖ БУЙ ТӨРИЙН БОДЛОГО, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ХҮРЭЭНД						
2.1	Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа бүх төрлийн геологийн судалгааны ажил, ашигт малтмал, газрын тосны уламжлалт болон уламжлалт бус эх үүсвэрийн эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагааг хууль бусаар зогсоох, саад учруулахгүй байх, төлөвлөгөө, тайланг хуулийн хугацаанд түргэн шуурхай хянан баталгаажуулах талаар сум, орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, иргэдэд танилцуулах, саад учруулах үйлдэл гаргасан тохиолдолд хуулийн хариуцлага тооцох арга хэмжээг авч хэрэгжүүлэх, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд хуульд заасны дагуу хяналт тавьж ажиллах;	-	Хийсэн хяналт шалгалтын тоо	2	1	Аймгийн Засаг даргын 2023.05.22 өдрийн А/323 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг нийт 38 талбайд хийж Албан шаардлага –11, үйл ажиллагааг зогсоох акт-1, хяналт шалгалтаар Зөвлөмж – 14, тorgууль-24,500,000 төгрөг, нөхөн төлбөрийн актаар 3,300,000 төгрөг тус тус ноогдуулж тorgууль нөхөн төлбөрийн барагдуулалт 100% хийгдсэн. Мөн Дундговь аймгийн Эрдэнэдалай, Дэлгэрхангай, Сайхан-Овоо сумдын нутаг дэвсгэрт нүүрсний давхаргын метан хийн хайгуулын үйл ажиллагаа явуулдаг “Тахь Ресурс” ХХК-ийн мэдээлэл аймгийн ИТХ-н ээлжит хуралдаанд танилцуулж тус талбайд хайгуул хийхийг эсэргүүцэж буй Сайхан-Овоо сумын уугуул суугуул иргэдийг хүлээн авч уулзан тэдний санал сэтгэгдлийг сонсож ИТХ-ын дарга С.Од-Эрдэнэ, Аймгийн Засаг дарга Ц.Мөнхбат нар иргэдийн асуусан асуултад хариулж хариу тайлбар өгөв. Мөн Дэрэн сумын нутагт хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий Генерго ХХК 2023 оны хайгуулын ажлаа Дэрэн сумын ИТХ-д танилцуулав. <b>Хэрэгжилт 100 хувь</b>
2.2	Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлттэй уялдуулж шинжлэх ухааны үндэслэлтэй гүйцэтгэсэн геологийн судалгааны ажлын үр дүнд тогтоосон ашигт малтмалын хэтийн төлөвлтэй талбайг сонгон шалгаруулалтын талбайгаар зарлахтай холбоотой саналаа хууль, тогтоомжийн хүрээнд хугацаанд нь өгөх	-	Өгсөн саналын тоо	-	2	Ашигт малтмал газрын тосны газраас манай аймагт хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох боломжтой 76 байршилд 177579.96 га талбайд ялган ирүүлсний дагуу 12 талбайд зөвшөөрсэн санал, 64 талбайд татгалзсан саналыг хууль, тогтоомжийн хүрээнд хугацаанд нь 2 саналыг хүргүүлсэн. <b>Хэрэгжилт 100 хувь</b>

2.3	Орон нутагт ашигт малтмалыг хууль бусаар олборлохыг таслан зогсоох ажлыг санаачлан зохион байгуулах	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	1	2	Дундговь аймгийн Өлзийт сумын 1-р багийн нутаг “Загийн ус” улсын тусгай хамгаалалттай газарт түгээмэл тархацтай ашигт малтмал буюу элс зөөвөрлөсөн талаар улсын тусгай хамгаалалттай газрын байгаль хамгаалагчийн мэдээллийн дагуу газар дээр нь сумын хэсгийн төлөөлөгч, байгаль орчны хамтарсан ажлын хэсэг нөхцөл байдалтай танилцан 2 машин элс ачсан зөөвөрлөх гэж байсан иргэнийг саатуулан, элс зөөвөрлөсөн газрын талбайн хэмжээг тодорхойлон зөрчлийг арилгуулахаар Цагдаагийн байгууллагад шилжүүлсэн. Гурван сайхан сумын 4-р баг Өндөр-Элст гэх газарт хайгуулын тусгай зөвшөөрөлтэй Жеммэри сүрвэй ХХК ашиглалтын үйл ажиллагаа явуулж байна гэх нутгийн иргэдийн гомдолоор экологийн цагдаагийн алба, уул уурхайн байцаагчдын хамтарсан хяналт, шалгалт хийж үйл ажиллагааг зогсоосон. Хууль бусар ашигт малтмал олборлох хэрэг зөрчил 2022 онд 5 удаа бүртгэгдэж байсан бол энэ онд 2 удаа бүртгэгдэж хэрэг зөрчлийн тоо 60 хувь буурсан байна. <b>Хэрэгжилт 100 хувь</b>
2.4	Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах явцад бусад төрлийн ашигт малтмал ашиглахгүй байх талаар зохих арга хэмжээ авах, түүх, соёлын олдвор, эд өлгийн зүйл илэрсэн тохиолдолд үйл ажиллагааг зогсоох арга хэмжээ авч, холбогдох газар мэдээлэх;	-	Хяналт шалгалтын тоо	1	3	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий талбайнуудад аймгийн ЗДТГ, цагдаагийн газар, Экологийн цагдаагийн албанаас нийт 3 удаагийн хяналт шалгалтыг зохион байгуулахад түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй 1 аж ахуйн нэгжийн хууль бус үйл ажиллагааг зогсоож холбогдох хяналтын байгууллагад шилжүүлсэн. <b>Хэрэгжилт 100 хувь</b>
2.5	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг дэмжих;	-	Олборлох үйлдвэрлэлийн ил тод	1	1	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын ажлын албанаас ирсэн чиглэлийн дагуу Аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар

			байдлын тайланг хүргүүлсэн эсэх /Тийм-1, угүй-0/				сарын 15-ны А/378 дугаар захирамжаар Уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуй нэгжтэй байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай гурвалсан гэрээний төслийг боловсруулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, гэрээ дүгнэх, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх дэд зөвлөлийг 9 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсан. 2023 онд олборлолтын үйл ажиллагаа явуулсан 8 аж ахуй нэгжийн орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төрийн байгууллагад олгосон хандив, тусlamжийн дэлгэрэнгүй мэдээллийг 15 нэр төрлөөр гарган олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын ажлын албандаа хүргүүлэв. <b>Хэрэгжилт 100 хувь</b>
2.6	“Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журам”-ыг хэрэгжүүлэх талаар төрийн захирагааны байгууллагуудтай хамтран ажиллах;	40.0 Хувийн хэвшил	Хамтран ажилласан байгууллагын тоо	3	7		Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт үйл ажиллагаа явуулдаг “Эрдэнэс силвер ресурс” төрийн өмчит компани нь Канад Улсын Засгийн газрын санхүүжилттэй “Монгол Улс: Институцийн веерчлэлт хийх замаар эрдэс баялгийн менежментийг сайжруулах нь” (MERIT) төсөл, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Байгаль орчин аялал жуулчлалын яам, Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар, Гурвансайхан сумын Засаг даргын тамгын газар, Уурхайн нэлөөллийн бүсийн иргэд, олон нийтийн оролцоотойгоор “Салхитын менгэ, алтны ордын хаалтын менежментийн төлөвлөгөө боловсруулах” жишиг төслийг 2021 оны 9 дүгээр сараас 2023 оны 5 дугаар сарын хооронд буюу хоёр жилийн хугацаанд амжилттай хэрэгжүүлсэн бөгөөд нийт төрийн болон хувийн хэвшлийн 9 байгууллагатай хамтран ажилласан.

							<p>Энэхүү төсөл нь Монгол Улсад уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөөг боловсруулах анхны сайн туршлага нэвтрүүлж, хариуцлагатай уурхайг хөгжүүлэхэд терийн болон нутгийн захиргааны байгууллагууд, орон нутгийн иргэдийн чадавхийг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулсан жишиг төсөл болсон.</p> <p>АНУ-ын Невада мужийн Рено хотод 2023 оны 10 дугаар сарын 2-7ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Уурхайн хаалт 2023” 16 дахь удаагийн Олон Улсын хуралд Монгол Улсаа төлөөлөн оролцож төслийн сайн туршлага, үр дүнгийн талаар танилцуулгыг “Салхитын менгэ, алтны ордын хаалтын менежментийн төлөвлөгөө боловсруулах” жишиг төслийн орон нутгийн ажлын хэсгийн ахлагч Дундговь аймгийн Засаг даргын орлогч М.Анхбаяр, MERIT төслийн ажилтан Р.Эрдэнэчимэг нар илтгэл тавьж оролцсон. <b>Хэрэгжилт 100 хувь</b></p>
2.7	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарт тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн мод тарих үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж хамтран ажиллах. Тухайн бус нутгийн хөрс, цаг агаарын онцлогт тохируулан тарих модны тоо, газрын байршил, хэмжээг тогтоох чиглэлээр тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй хамтран ажиллаж, хяналт тавих;	18.7 Хувийн хэвшил	Шинээр тарьсан модны тоо	8000	9000	<p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 8 аж ахуй нэгж өөрсдийн эзэмшлийн талбайдaa 9350 ширхэг мод тарьж ургалтын хувь 84,4-тай байна. <b>Хэрэгжилт 100 хувь</b></p>	
			Ургалтын хувь	80	82		

2.8	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн А/114 дугаар тушаалаар батлагдсан Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт жендэрийн талаар баримтлах бодлого, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссан (1.4-1.10, 2.1-2.9, 3.1-3.2, 4.1-4.8) холбогдох үйл ажиллагааг хэрэгжүүлэх, биелэлтийг 2023 оны 11 сард багтаан ирүүлэх	Нөхөрлөлийн гишүүд	Тайланг хугацаанд нь хүргүүлсэн эсэх /Тийм-1, ҮГҮЙ-0/	-	1	"Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-д заасны дагуу Монголын бичил уурхайн нэгдсэн Дээвэр холбоо нь Ашигт малтмал газрын тосны газартай хамтран сургалтын хөтөлбөрөө боловсруулан баталж, орон нутагт бичил уурхайчдад хуваарийн дагуу сургалтыг Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоотой хамтран зохион байгуулсан. Дээрх сургалтаар Дундговь аймгийн бичил уурхайн 25 нөхөрлөлийн 239 гишүүн "Бичил уурхайн мэргэжлийн холбооны багц сургалт"-д суралцаж "ГЭРЧИЛГЭЭ"-гээ гардан авлаа. Мөн Сүхбаатар аймагт зохион байгуулсан Хүний нөөц, Жендэрийн манлайлагчдын нэгдсэн чуулганд Дундговь аймгаас төлөөлөл оролцлоо. Тайланг хүргүүлээгүй. Хэрэгжилт 0 хувь
2.9	Засгийн газрын 2022 оны 296 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ын хэрэгжилтийг хангаж ажиллах;	-	Хүлээн авсан хүсэлтийн тоо	-	11	296 дугаар журмын 8 дугаар зүйлийн 8.1-д заасан аймгийн Засаг даргын эрх үүргийн хүрээнд 2 удаагийн албан тоотоор сумдын Засаг дарга нарт "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ыг хэрэгжүүлж ажиллахыг чиглэл хүргүүлэв. 2023 онд нийт 6 сумын 11 талбайд хүсэлт ирснийг АМГТГ-т дүгнэлт гаргуулах хүсэлтийг хүргүүлсэн. Тус хүсэлтийн дүгнэлтээр Өндөршил сумын Нүдэн 1, 2 гэх талбайд тус тус 296 дугаар журмын дагуу бичил уурхайгаар ашигт малтмал олборлох боломжтой гэсэн дүгнэлт ирсэн. Тус 2 талбайг Өндөршил сум ИТХ-р хэлэлцэж бичил уурхайгаар тусгай хэрэгцээнд авахаас татгалзсанаар аймгийн хэмжээнд бичил уурхайн талбай байхгүй байна. Хэрэгжилт 100 хувь

2.10	"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 10 дугаар сарын 04-ны өдрийн 157 дугаар захирамжаар байгуулагдсан "Хот, хөдөөгийн сэргэлт" ажлын хэсгийн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хамtran ажиллах;	ОНТ 10,0	Хамtran ажилласан үйл ажиллагааны тоо	-	2	"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нээлттэй Дундговь хөрөнгө оруулагчдын чуулган, Уул уурхайн зөвлөгөөн-2023 арга хэмжээг зохион байгуулж уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгч 118 аж ахуй нэгжид урилга хүргүүлснээс 60 гаруй төлөөлөл ирж оролцов. Мөн Өмнөговь аймагт GOBI INVEST хөрөнгө оруулагчдын чуулганд оролцож Өмнөговь аймгийн Засаг даргатай уул уурхайн салбарт 5 чиглэлээр хамтарч ажиллах санамж бичиг байгуулав. <b>Хэрэгжилт 100 хувь</b>
------	---	-------------	---	---	---	--

**ГУРАВ. САЛБАРТ МӨРДӨГДӨЖ БҮЙ ТӨРИЙН БОДЛОГО, ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ОЛОН НИЙТЭД СУРТАЛЧЛАН, ТАНИУЛАХ, ИРГЭД, ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫГ МЭДЭЭ, МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД:**

3.1	Салбарт мөрдөгдөж бүй төрийн бодлого, хууль тогтоомжийг орон нутагт сурталчлан таниулах, хэрэгжүүлэх ажлыг холбогдох яам, агентлагтай хамtran зохион байгуулах;	10.0 ОНТ	Зохион байгуулсан сургалтын тоо	1	4	Нээлттэй- Дундговь хөрөнгө оруулагчдын чуулган, Уул уурхай-2023 зөвлөгөөн, Удирдлагын манлайлал-2023 уулзалт, Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоотой хамtran бичил уурхайчдын зөвлөгөөнүүдийг тус тус холбогдох байгууллагуудтай хамtran зохион байгуулж аймгийн уул уурхай, эрдэс баялгийн салбарын өнөөгийн байдал, анхаарах асуудлыг танилцуулж цаашдын хамтын ажиллагааны талаар хэлэлцүүлэг зохион байгуулж ажиллав. Сургалт, зөвлөгөөнд нийт давхардсан тоогоор 629 хүн оролцсон байна. <b>Хэрэгжилт 100 хувь</b>
3.2	Засаг даргын Тамгын газрын уул уурхайн асуудал хариуцсан мэргэжилтэнг салбарын шинэ мэдээллээр хангах, холбогдох сургалтад хамруулах ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;	-	Хамрагдсан сургалтын тоо	3	3	Мэрит төслөөс хэрэгжүүлсэн УУХҮЯ, БОАЖЯ, АМГТГ, Усны газар, Үндэсний геологийн алба зэрэг салбарын дээд гатны байгууллагын үйл ажиллагаатай танилцах, зөвлөгөө мэдээлэл авах 3 хоногийн сургалт, Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрийн уурхайтай танилцах, Ойн генетик нөөцийн Эрдэнэт төвийн үйл

							ажиллагаатай танилцах Модлог ургамлын үрийн худалдаа, солилцоо хийх, иргэд ААН-д үрийн боловсрол олгох SEED EXPO-2023-д. Аж үйлдвэржилтийн үндэсний зөвлөгөөнд уул уурхайн мэргэжилтэн оролцсон MINING WEEK-2023 Уул уурхайн долоо хоногт оролцож нийт 4 удаагийн сургалтад хамрагдсан байна. <b>Хэрэгжилт 100 хувь</b>
3.3	Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон нутгийн захиргааны байгууллагын хооронд байгуулсан гэрээ бүрийг <a href="http://www.iltodgeree.mn">www.iltodgeree.mn</a> эрдэс баялгийн гэрээний мэдээллийн санд байршуулж гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, тайланг жил бүрийн 12 дугаар сарын 25-ны дотор төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;	-	Ил тод мэдээлсэн гэрээний тоо	10	15		Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон нутгийн захиргааны байгууллагын хооронд байгуулсан 15 гэрээг <a href="http://www.iltodgeree.mn">www.iltodgeree.mn</a> эрдэс баялгийн гэрээний мэдээллийн санд байршуулав. Гэрээний биелэлтийг дүгнэх Хамтын ажиллагааны хороо 2024 оны нэгдүгээр улиралд багтаан дүгнэх уулзалт арга хэмжээг зохион байгуулж олон нийтэд танилцуулна. <b>Хэрэгжилт 100 хувь</b>
3.4	Түгээмэл тархацтай ашигт малтмал, барилгын материалын ашиглалт, олборлолтын мэдээ, нөөцийн хөдөлгөөний мэдээллийг Ашигт малтмал, газрын тосны газрын чиглэл хариуцсан нэгжид хуулийн хугацаанд ирүүлэх;	-	Мэдээллийг хугацаанд нь хүргүүлсэн эсэх Тийм-1 Үгүй -0	-	1		Ашигт малтмал, газрын тосны газарт түгээмэл тархацтай ашигт малтмал, барилгын материалын ашиглалт, олборлолтын мэдээ, нөөцийн хөдөлгөөний мэдээллийг хугацаанд нь хүргүүлсэн. Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын барилгын хэлтэст элс хайрга хайх, олборлох тусгай зөвшөөрөл бүхий талбайн судалгааг хүргүүлэв. <b>Хэрэгжилт 100 хувь</b>
3.5	Ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдийн орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд төвлөрүүлж байгаа орлого тухайн сум, орон нутгийн хөгжилд хэрхэн нөлөөллөө үзүүлж, үр ашгаа үзүүлж байгаа талаар болон хариуцлагатай уул уурхайг	-	Үйл ажиллагааг нь сурталчилсан ААН-н тоо	-	4		Үнэн бэх, Хуучин-Андууд, Гурвансайхан, Эрдэнэс силвер ресурс ХХК-үүд уул уурхайн зөвлөгөөнөөр өөрсдийн үйл ажиллагааг болон улс, орон нутагт өгсөн татвар төлбөр, хандив тусlamжаа сурталчлан, танилцуулав. Мөн сумдад төвлөрүүлж байгаа орлого, бусад хандив тусlamж тухайн сум, орон нутгийн хөгжилд хэрхэн нөлөөллөө үзүүлж, үр ашгаа үзүүлж байгаа талаар Гурвансайхан,

	хөгжүүлж байгаа аж ахуйн нэгжүүдийг сурталчлах, тухайн жилийн эцэст дээрх орлогын үр өгөөжийн талаар тайланг ирүүлэх;				Өндөршил, Өлзийт сумдууд илтгэл мэдээллийг танилцуулсан. <b>Хэрэгжилт 100 хувь</b>
3.6	Тусгай зөвшөөрлөөр олгосон талбайг орон нутгийн тусгай хэрэгцээнд авахаар төлөвлөж байгаа болон авсан тохиолдолд нөхөн төлберийн асуудлыг төсөвт тусгуулан шийдвэрлүүлэх, холбогдох мэдээллийг тухай бүр ирүүлэх;	-	Ирсэн нөхөн төлбөр тооцуулах хүсэлтийн тоо	-	Тусгай зөвшөөрлөөр олгосон талбайг орон нутгийн тусгай хэрэгцээнд авахаар төлөвлөж байгаа болон авсан тохиолдолд одоогоор байхгүй байна. Тиймээс үнэлгээнээс хасч тооцов.
3 зорилт, 22 заалтаас Хэрэгжилт: 100 хувь- 21, 0 хувь-1,			95,4		


  
 АДГУУСАН  
 БАТАЛГААЖКУУЛСАН  
 АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Д.МОНХБАТ

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:  
 ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН  
 АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

  
 Э.ОДОНЧИМЭГ

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:  
 ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨДТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
 МЭРГЭЖИЛТЭН

  
 М. ГАНЧИМЭГ

Дундговь аймгийн Засаг даргын Монгол улсын засгийн газрын гишүүн, уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдтай 2023 онд хамтран ажиллах гэрээний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын тайлан

2023 оны 11 дүгээр сарын 29

Мандалговь хот

### НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Уул уурхай хүнд үйлдвэрийн сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүнг хянах, үнэлэх, дүгнэлт зөвлөмж гаргах, үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналтыг сайжруулж, цаашид гарах үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэхэд оршино.

#### ХОЁР.ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Уул уурхай хүнд үйлдвэрийн сайдтай байгуулсан аймгийн Засаг даргын хамтран ажиллах гэрээний 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.2-т заасан арга зүйгээр Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсээс ирүүлсэн тайланд үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлзээ.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан хамтран ажиллах гэрээний 2023 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж хэрэгжилт удаашралтай арга хэмжээний жагсаалтыг гарган холбогдох хэлтэст хүргүүлэн цаашид анхаарах асуудал дээр өгч ажилласан.

#### ГУРАВ.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Аймгийн Засаг дарга хамтран ажиллах гэрээгээр 23 үүргийг хүлээж, үүргийг орон нутагт хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган үр дүнг тооцож ажилласнаар жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 95.4 хувьтай байна. 21 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн буюу 100 хувь, 1 арга хэмжээ үр дүнгүй буюу 0 хувьтай хэрэгжүүлсэн байна. Нийт 23 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэхээс 1 арга хэмжээ буюу Тусгай зөвшөөрлөөр олгосон талбайг орон нутгийн тусгай хэрэгцээнд авахаар төлөвлөж байгаа болон авсан тохиолдолд одоогоор байхгүй байгаа тул үнэлгээнээс хасаж тооцов.

**Хүснэгт:**

№	Үнэлгээ	Арга хэмжээний тоо	Бүрэн хэрэгжсэн /90 хувиас дээш/	Бүрэн хэрэгжээгүй /90 хувиас доош/	Хангалтгүй хэрэгжүүлсэн
1	Салбарын үйл ажиллагааг дэмжих чиглэлээр	7	7	-	-
2	Салбарт мөрдөгдөж буй төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд	10	9	-	1
3	Салбарт мөрдөгдөж буй төрийн бодлого, хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан, таниулах, иргэд, төрийн захиргааны байгууллагыг мэдээ, мэдээллээр хангах арга хэмжээний хүрээнд:	5	5	-	-
	Нийт	22	21	-	1

**ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖСЭН ОНЦЛОХ АЖЛУУД:**

2023 онд "Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх гэрээний загвар"-ын дагуу аймгийн нутаг дэвсгэрт олгогдсон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч 15 ААН-тэй гэрээ байгуулан гэрээгээр хүлээсэн үүргийн хүрээнд 2023 онд 210 сая төгрөгийн мөнгөн хандив, мөнгөн бусаар 15 оюутны сургалтын төлбөр, өвөлжилтийн бэлтгэл байдалд 2000 тн нүүрс, 3000 ш өвс, ногоон байгууламжийн хашаа 50.0 сая, усалгааны материал 50.0, шинээр 35500 ш мод тарих, ан амьтны биотехник 3.0 сая, орон нутгийн үйлдвэрлэгчдээс 40 ш ажилчдын хувцас худалдан авах, булаг хаших 2.0 сая, Мал угаалгын бант 15.0 сая, нөхөн сэргээлт 10.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын хандив тусlamж хүлээн авсан байна.



Аймгийн Засаг даргын 2023.05.22 өдрийн А/323 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг нийт 38 талбайд хийж Албан шаардлага –11, үйл ажиллагааг зогсоох акт-1, хяналт шалгалтаар Зөвлөмж – 14, торгууль-24,500,000 төгрөг, нөхөн төлбөрийн актаар 3,300,000 төгрөг тус тус ноогдуулж торгууль нөхөн төлбөрийн барагдуулалт 100% хийгдсэн. Мөн Дундговь аймгийн Эрдэнэдалай, Дэлгэрхангай, Сайхан-Овоо сумдын нутаг дэвсгэрт нүүрсний давхаргын метан хийн

хайгуулын үйл ажиллагаа явуулдаг “Тахь Ресурс” ХХК-ийн мэдээлэл аймгийн ИТХ-н ээлжит хуралдаанд танилцуулж тус талбайд хайгуул хийхийг эсэргүүцэж буй Сайхан-Овоо сумын уугуул суугуул иргэдийг хүлээн авч уулзан тэдний санал сэтгэгдлийг сонсож ИТХ-ын дарга С.Од-Эрдэнэ, Аймгийн Засаг дарга Ц.Мөнхбат нар иргэдийн асуусан асуултад хариулж хариу тайлбар өгөв.



Канад Улсын Засгийн газрын санхүүжилттэй “Монгол Улс: Институцийн өөрчлөлт хийх замаар эрдэс баялгийн менежментийг сайжруулах нь” (MERIT) төсөл хаалтын арга хэмжээгээ зохион байгуулж Салхитын уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөөг үндэсний болон олон улсын зөвлөхүүд хамтран боловсруулж, хүлээлгэн өгөв.



Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 4 сумд үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн компаниуд өөрсдийн талбайд 9350 ширхэг мод тарьж ургуулсан.



Уул уурхайн салбарын хууль, тогтоол шийдвэрийг сурталчлах ажлын хүрээнд 4 удаагийн арга хэмжээ зохион байгуулагдаж сургалт мэдээлэл өгч давхардсан тоогоор 629 иргэнийг хамруулсан.



### ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх арга хэмжээний уул уурхайн салбарын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг 95,4 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлж үнэлгээний саналыг хургуулж байна.

Гэрээгээр хүлээсэн үүргийн хүрээнд 96.6 сая төгрөгийг зарцуулан хэрэгжүүлсэн байна. Үүнд орон нутгийн төсөв 20.0 сая, байгууллагын төсөв 58.7 сая,

нөхөрлөл хоршооны гишүүдийн хөрөнгө 17.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн.

Уул уурхайн яамны сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан гэрээний үүргийг орон нутагт хэрэгжүүлэн ажиллахаар 23 заалт бүхий төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажилласан бөгөөд үр дүнгүй хэрэгжсэн 1 заалт байгаа нь

“Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн А/114 дугаар тушаалаар батлагдсан Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт жендэрийн талаар баримтлах бодлого, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссан (1.4-1.10, 2.1-2.9, 3.1-3.2, 4.1-4.8) холбогдох үйл ажиллагааг хэрэгжүүлэх, биелэлтийг 2023 оны 11 сард багтаан ирүүлэх” гэсэн арга хэмжээний хүрээнд Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбооны гүйцэтгэх захирал Э.Оюунболдын ахалсан баг бүрэлдэхүүнтэй хамтран 2023 оны 01 дүгээр сард 2 өдрийн бичил уурхай эрхлэгчдийн сургалтыг зохион байгуулж сургалтад бичил уурхайн 25 нөхөрлөлийн 239 гишүүн “Бичил уурхайн мэргэжлийн холбооны багц сургалт”-д суралцаж “ГЭРЧИЛГЭЭ”-гээ гардан авлаа.

Мөн Сүхбаатар аймагт зохион байгуулсан Хүний нөөц, Жендэрийн манлайлагчдын нэгдсэн чуулганд Дундговь аймгаас төлөөлөл оролцсон зэрэг тодорхой ажлууд хийгдсэн байгаа хэдий ч Жендэрийн талаар баримтлах бодлогод тусгагдсан холбогдох заалтуудын хэрэгжилтийг гарган хугацаанд нь хүргүүлэх ажил хийгдээгүй байна.

#### ТАВ. ЗӨВЛӨМЖ

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст:

1. Орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудын ашигт малтмалын хайгуул, олборлолтын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй компаниудаас хүлээн авсан мөнгөн болон мөнгөн бус хандивыг нийтэд мэдээлэх ажлыг холбогдох хуулийн дагуу мэдээлж байх

2. Гэрээнд тусгагдсан үүргийн хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөхдөө суурь түвшин, хүрэх түвшнийг бодитой судалгаанд үндэслэн тодорхойлох

3. Тайланг гаргахдаа шалгуур үзүүлэлтийн дагуу хүрэх түвшинд хүрсэн эсэхийг тайлагнахаас гадна үр дүн, үр нөлөөний талаар тайлагнаж хэвших мөн нотлох баримтыг тайландаа хавсаргаж байх

4. Дараа оны гэрээний төсөлд төсөв хөрөнгө нь тодорхой, үр дүн гарагуйц бодитой ажлуудыг тусгах саналыг яам руу уламжлах

5. Гэрээгээр хүлээх үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилт үр дүнгийн талаар аймгийн Засаг дарга болон хэлтсийн даргыг тухай бүр мэдээллээр ханган хэрэгжилтийн тайланг хугацаанд нь чанартай гаргаж тайлагнаж байхыг ажил хариуцсан мэргэжилтэн анхаарч ажиллах

Баталгаажуулсан:	
Аймгийн Засаг дарга	Ц.Мөнхбат
Хянасан:	
Хяналт шинжилгээ, унэлгээний хэлтсийн дарга	Д.Даариймаа
Тайлан бичсэн:	
Хяналт шинжилгээ, унэлгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн	